



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 337

Улаанбаатар хот

### Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага"-ыг батлах тухай 245 дугаар тогтоолын хавсралтын 9.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Баялаг тасгон" ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсүгэй.

2. Хадгаламж, зээлийн хоршооны санхүүгийн тогтвортой байдал, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны "Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт"-ийг тогтоох тухай 246 дугаар тогтоолын хавсралтын 1.5 дахь хэсгийг ханган, гишүүдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд мөрдөн ажиллахыг "Баялаг тасгон" ХЗХ-ны тэргүүлэгчдийн зөвлөл /Я.Налжирмаа/, хяналтын зөвлөл /И.Батцэцэг/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын 2-т заасан үүрэг даалгаврын биелэлтийг 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хангаж ажиллаагүй тохиолдолд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг "Баялаг тасгон" ХЗХ /М.Даваадулам/-нд анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын албанд ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН